Монгол улсын хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээ

Г.Шинэжаргал[1,2], Ц.Басбиш[1], Lee Wonhee[3]

[1]АШУҮИС, Сувилахуйн сургууль, НЭМСТ
[2]ХСҮТ, Эрчимт эмчилгээний сувилагч
[3]ОУУБИС, Сувилахуйн сургууль
Цахим шуудан: newjargal0101@gmail.com, Утас: 88006632

Түлхүүр үг:

Сувилахуйн тусламжийн чанар
Өвчтөний үнэлгээ
Хавдар
Сувилагч
3-р шатлалын эмнэлэг

Товч утга:

Үндэслэл: Монгол Улсад 2021 онд 5981 хавдраар оношлогдож, 4559 хүн хорт хавдрын улмаас нас барсан байна. Монгол улсад 100 мянган хүн ам тутамд 229 хүн хорт хавдраар өвчилж байгаа ба энэ өвчинд өртөж буй иргэдийн 80 хувь нь 45-аас дээш насныхан байна. Улсын хэмжээнд 24 мянган хүн хорт хавдрын шалтгаанаар ХСҮТ-ийн хяналтанд эмчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээгч авч байна[1]. Хорт хавдар өвчин нь удаан явцтай хоруу чанартай, удаан хугацаанд эмчилгээ сувилгаа шаардагддаг өвчин юм[2]. 2013 онд улсын эмнэлэгүүдэд хийгдсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар 62.4 хувь нь эмчилгээ үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байгааг харуулсан[3]. Сэтгэл ханамжийн байдалд сувилагчийн гардан үйлдлээ тайлбарлах байдал, сувилагчийн сувилгаа анхаарал халамж болон цэвэр тохьтой орчин чухал нөлөө үзүүлдэг[4]. Хавдар судлалын үндэсний төвийн сувилахуйн тусламж үйлчилгээг судалсан судалгаа одоогоор байхгүй байгаа учир энэхүү судалгааг хийх үндэслэл болсон. **Зорилго:** Хавдар Судлалын Үндэсний Төвд хэвтэн эмчлүүлж буй хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээ, нөлөөлөх хүчин зүйлсийг судлах. **Арга, аргачлал:** Хавдар судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлж буй 265 өвчтөнөөс хялбаршуулсан түүврийн аргыг ашигласан судалгааг авсан. Судалгааны мэдээллийг нийгэм хүн ам зүйн асуумж болон хавдар судлалын сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх (Quality Oncology Nursing Care Scale-QONCS) асуумж ашиглан нэг агшингийн судалгааны загварыг ашиглаж хийсэн. **Үр дүн:** Тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний дундаж оноо нь 136.96±19.54 буюу хорт хавдартай үйлчлүүлэгчид нийт сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлсэн байв. Дэд бүлгээр нь авч үзвэл үйлчлүүлэгчийг дэмжсэн байдал дэд бүлгийн дундаж оноо нь 70.86±9.20; холбоо хамааралтай байдлын дундаж оноо нь 18.44±5.15; үнэ цэнэтэй байдал дэд бүлгийн дундаж оноо нь 17.93±2.45; хүндлэгдсэн байдал дэд бүлгийн дундаж оноо нь 13.23± 2.00 буюу хорт хавдартай үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр эдгээр тусламж үйлчилгээ сайн түвшинд үнэлэгдсэн байна. Харин итгэл үнэмшлийн дэд бүлгийн дундаж оноо нь 16.49±7.65 буюу хорт хавдартай үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр дунд түвшинд үнэлэгдсэн байна. Иймд сувилагч нар хорт хавдартай үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үзүүлэхдээ итгэл үнэмшил, сүнслэг байдлыг тусламж үйлчилгээнд анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна. Тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ болон хүйс сөрөг, сул хамааралтай (r=-0.152, p=0.013), мөн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ нь судалгаанд оролцогсдын боловсролын түвшинтэй сөрөг, сул хамааралтай байв (r=-0.25, p=0.0001). Олон регрессийн шинжилгээгээр хүйс (R2=.02) болон боловсрол (R2=.06) нь өвчтөний сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний таамаглагч хувьсагч болж байна. **Дүгнэлт:** 1.Хорт хавдартай үйлчлүүлэгчид нийт сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлсэн байв. 2.Хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээнд хүйс болон боловсрол нь статистик ач холбогдол бүхий чухал нөлөөлөгч хүчин зүйл байв.

Үндэслэл: Улсын хэмжээнд 24 мянган хүн хорт хавдрын шалтгаанаар ХСҮТ-ийн хяналтанд эмчилгээ, сувилахуйн тусламж үйлчилгээгч авч байна. Энэ өвчний үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ эмч, сувилагчдаас маш өндөр ур чадвар шаарддаг. Сувилагч бидний үйлчлүүлэгчиддээ гол анхаарах зүйл нь цэвэр сайхан орчин нөхцлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл зүйг анхаарч, сувилахуйн үед илэрч байгаа шинж тэмдгүүдийг мэдэрч, түүнийг илрүүлж, оношилж түүнийхээ дагуу тусламж үйлчилгээг үзүүлж чаддаг байх ёстой. Хавдар өвчнөөр шаналж буй хүмүүст нэн тэргүүнд шаардлагатай зүйлийн нэг нь чанартай сувилахуйн тусламж үйлчилгээ юм.[2] Сувилахуйн тусламжийн чанар нь дэлхийн аль ч улсын эрүүл мэндийн байгууллагын гол төв нь байдаг. Гэвч хүний нөөцийн хомсдол, ажлын ачаалал, ажиллах орчин гэх мэт олон хүчин зүйлүүдийн улмаас сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад олон бэрхшээл тулгарч байна.[5] Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар гэдэг нь өвчтөний бие махбод, сэтгэл зүй, сэтгэл хөдлөл, нийгэм, итгэл үнэмшлийн хэрэгцээнд нь нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэхийг хэлнэ.[6-9]

Сувилагч нь эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн ажилчдын ихэнх хувийг бүрдүүлдэгээс гадна, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон чанарт чухал үүрэг хариуцлага хүлээдэг хамгийн гол хүний нөөц 2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 13112 мэргэжлийн сувилагч байна[10]. Монгол улс нь сувилагчийн хүний нөөцийн хомсдолтой байгаа бөгөөд сувилагч өвчтөний харьцаа 1:20-30 байна. Энэ нь Монгол улсын сувилагчийн тоо олон улсын стандартаас 2 дахин бага байгааг харуулж байгаа юм[11,14] 2013 онд улсын эмнэлэгүүдэд хийгдсэн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар 62.4 хувь нь эмчилгээ үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байгааг харуулсан.[3] Хавдар судлалын үндэсний төвийн сувилахуйн тусламж үйлчилгээг судалсан судалгаа одоогоор байхгүй байгаа учир энэхүү судалгааг хийх үндэслэл болсон.

Зорилго: Хавдар Судлалын Үндэсний Төвд хэвтэн эмчлүүлж буй хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээ, нөлөөлөх хүчин зүйлсийг судлах.

Зорилт:

1. Хэвтэн эмчлүүлж буй хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээг тодорхойлох
2. Хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээнд хүн ам зүйн мэдээллийн хүчин зүйлийн нөлөөг судлах

Арга, аргачлал: Хавдар судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлж буй 265 өвчтөнөөс хялбаршуулсан түүврийн аргыг ашигласан судалгааг авсан. Судалгааны мэдээллийг нийгэм хүн ам зүйн асуумж болон хавдар судлалын сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг үнэлэх Charalambous.A (2014) нарын аргачлалаар (Quality Oncology Nursing Care Scale-QONCS) асуумж ашиглан нэг агшингийн судалгааны загварыг ашиглаж хийлээ. Энэхүү асуумж нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байх үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний талаарх өвчтөнүүдийн төсөөлөл, хүлээлтэд тулгуурлан сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлэх 34 асуулт, 5 дэд бүлгээс бүрдэнэ. Судалгааны өгөгдөлийг SPSS 21.0 программ ашиглан статистик боловсруулалт хийн үр дүнг тооцож гаргасан.

Ёс зүйн зөвшөөрөл: ОУУБИС-ийн ёс зүйн хорооны 2022 оны 12 сарын 01-ийн өдрийн IRB No.49 дугаарын зөвшөөрөл, ХСҮТ-ийн НЭМТСА-ны 2023 оны 02 сарын 16-ийн өдрийн хурлын шийдвэрийн дагуу энэхүү судалгааг хийж гүйцэтгэв

Үр дүн: Судалгаанд хамрагдсадын нас 22-84-ийн хооронд хэлбэлзэж, дундаж нас нь 54.30 (SD=12.77) байсан бөгөөд судалгаанд оролцогчдын дийлэнх нь 61.1%, (n=162) эмэгтэйчүүд байна. Судалгаанд оролцогчдыг боловсролоор нь ангилж үзвэл 14.3% (n=38) бүрэн дунд боловсрол, 53.6% (n=142) дунд; үлдсэн 32.1% (n=85) нь бакалавр болон түүнтэй адилтгах түвшний боловсролтой байв. Судалгаанд оролцогчдын ихэнх нь n=209 (78.9%) гэрлэсэн бөгөөд 139 (52.5%) оролцогчдын талаас илүү хувь нь хөдөө орон нутагт амьдардаг байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд хамрагсадын нийгэм, хүн ам зүйн үзүүлэлтүүд (n=265)

Үзүүлэлтүүд	Давтамж	Хувь
Нас (дундаж 54.3094 SD=12.77109)		
Хүйс		
Эрэгтэй	103	38.9
Эмэгтэй	162	61.1
Гэрлэлтийн байдал		
Гэрэлсэн	209	78.9
Ганц бие	20	7.5
Салсан	4	1.5
Бэлэвсэн	14	5.3
Хамтран амьдрагч	16	6.0
Бусад	2	0.8
Боловсролын түвшин		
Бүрэн дунд	38	14.3
Дунд	142	53.6
Дээд	85	32.1
Хаана оршин суудаг		
Улаанбаатар	126	47.5
Хөдөө орон нутаг	139	52.5

Тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний дундаж оноо нь 136.96±19.54 буюу хорт хавдартай үйлчлүүлэгчид нийт сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлсэн байв.

Дэд бүлгээр нь авч үзвэл үйлчлүүлэгчийг дэмжсэн байдал дэд бүлгийн дундаж оноо нь 70.86±9.20; холбоо хамааралтай байдлын дундаж оноо нь 18.44±5.15; үнэ цэнэтэй байдал дэд бүлгийн дундаж оноо нь 17.93±2.45; хүндлэгдсэн байдал дэд бүлгийн дундаж оноо нь 13.23± 2.00 буюу хорт хавдартай үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр эдгээр тусламж үйлчилгээ сайн түвшинд үнэлэгдсэн байна. Харин итгэл үнэмшлийн дэд бүлгийн дундаж оноо нь 16.49±7.65

буюу хорт хавдартай үйлчлүүлэгчдийн үнэлгээгээр дунд түвшинд үнэлэгдсэн байна. Иймд сувилагч нар хорт хавдартай үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үзүүлэхдээ итгэл үнэмшил, сүнслэг байдлыг тусламж үйлчилгээнд анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Судалгаанд хамрагсадын сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээг тодорхойлсон дүн (n=265)

Нийт СТЧ болон дэд бүлгүүд	Бага утга	Их утга	Дундаж	Стандарт хазайлт	Түвшин
Сувилахуйн тусламжийн чанар	69	170	136.96	19.54	Сайн
Дэмжсэн байдал	37.00	80.00	70.86	9.20	Сайн
Итгэл үнэмшлийн тусламж	6.00	30.00	16.49	7.65	Дунд
Холбоо хамааралтай байдал	5.00	25.00	18.44	5.15	Сайн
Үнэ цэнэтэй байдал	4.00	20.00	17.93	2.45	Сайн
Хүндлэгдсэн байдал	3.00	15.00	13.23	2.00	Сайн

Тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ болон хүйс сөрөг, сул хамааралтай (r=-0.152, p=0.013), мөн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ нь судалгаанд оролцогсдын боловсролын түвшинтэй сөрөг, сул хамааралтай байв (r=-0.25, p=0.0001). (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд хамрагсадын сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүн ам зүйн мэдээллийн хоорондын хамааралыг судалсан дүн (n=265)

Үзүүлэлтүүд	Нас	хүйс	Боловсролын түвшин	Орлого	Тусламж үйлчилгээний чанар
Нас	1				
Хүйс	-.151*	1			
Боловсролын түвшин	.200**	-	1		
Орлого	.257**	-	330**	1	
Тусламжийн чанар	-	.152*	.252**	-	1

Тайлбар: **P>0.05, **P>0.001 Pearson correlation coefficient*

Олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр хүйс (R^2=.02) болон боловсрол (R^2=.06) нь өвчтөний сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээний таамаглагч хувьсагч болж байна. Өөрөөр хэлбэл тусламж үйлчилгээний үнэлгээг хүйс 2%, боловсрол 6%-иар тус тус таамаглаж байна. Иймд сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээ нь өвчтөний боловсролын түвшин болон хүйсээс хамаарч байна гэж дүгнэж байна. Тухайлбал боловсрол бага байх тусам одоогийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлж байна.(Хүснэгт 4)

Хүснэгт 4. Судалгаанд хамрагсадын хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээнд хүн ам зүйн мэдээллийн хүчин зүйлийн нөлөөг судалсан дүн (n=265)

Үзүүлэлтүүд	Коэффициент [a]			T утга	P утга	Collinearity Statistics	
	Стандарт бус коэффициентүүд		Стандарт коэффициент				
	B	Std. Алдаа	Бетта			Tolerance	VIF
Нас	-.112	.097	-.073	-1.154	.250	.874	1.145
Хүйс	5.807	2.412	.145	2.408	**.008**	.966	1.035
Боловсролын түвшин	-8.034	1.939	-.271	-4.142	**.000**	.821	1.219

Тайлбар: *a. Adjusted R^2=.082 ((хүйс (R^2=.02), боловсролын түвшин (R^2=.06))*

Хэлцэмж: Бидний судалгаагаар хорт хавдартай үйлчлүүлэгчдийн нийт 89.8% хувь нь сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлсэн байв. Бидний судалгааны үр дүн Zarzycka D, (2019) Gupta BS, (2014), Chang E, (2003) зэрэг судалгааны үр дүнтэй ойролцоо буюу үйлчлүүлэгчдийн 85-аас дээш хувь нь сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг өндрөөр үнэлсэн байна. Дэд бүлгээр нь авч үзвэл дэмжсэн байдал, холбоо хамааралтай байдал, үнэ цэнэтэй байдал, хүндлэгдсэн байдлын тусламж үйлчилгээг нийт үйлчлүүлэгчдийн 88.3%-94.7% нь сайн гэж үнэлэсэн байна. Харин итгэл үнэмшлийн дэд бүлгийн оноо нь дунд түвшинд (69.4%) үнэлэгдсэн нь сувилагч нар эмчилгээ, асаргаа сувилгаандаа анхаарлаа хэт хандуулж бусад буюу итгэл үнэмшлийг орхигдуулж байна хэмээн судлаач бид үнэлэж байна. Иймд сувилагч нар хорт хавдартай үйлчлүүлэгчдэд сувилахуйн тусламж үзүүлэхдээ итгэл үнэмшил,

сүнслэг байдлын тусламж үйлчилгээнд анхаарах хэрэгтэй байгааг харуулж байна.

Gishu.T, Weldetsadik AY, Tekleab AM (2019) нарын судлаачид 340 өвчтөн хамруулсан судалгааны үр дүнд боловсрол, гэрийн тусламж үйлчилгээний бэлтгэл, биемахбодын тусламж үйлчилгээний талаарх үнэлгээ бага буюу дундаж оноо 2.79 болон 2.89, сэтгэлзүйн тусламж үйлчилгээ болон сувилахуйн хүрэлцээний сэтгэл ханамж дунд буюу дундаж оноо 3.5 болон 3.83 тус тус байв. Энэ нь бидний судалгааны үр нь энэхүү судалгаатай дүнтэй ойролцоо буюу өвчтөнүүд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ (дундаж оноо 3.5) болон сувилахуйн тусламжийн хүрэлцээ (дундаж оноо 3.83) дэд бүлгүүдэд сэтгэл ханамжгүй байна. Өөрөөр хэлбэл өвчтөний боловсрол бага байх тусам одоогийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлж байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь буюу 53.6% (n=142) дунд боловсролтой бөгөөд эдгээр хүмүүс нь сувилахуйн тусламж үйлчилгээг авч байгаадаа сэтгэл хангалуун буюу сайн гэж үнэлсэн байна. Иймд сувилахуйн тусламж үйлчилгээний чанарын үнэлгээнд өвчтөний боловсролын түвшин ач холбогдол бүхий чухал нөлөөтэйг бидний судалгааны үр дүн харуулж байна. Харин Европын улсууд болох Грек, Кипр, Швед, Финлянд зэрэг орнуудад хэвтэн эмчлүүлж байгаа хавдартай өвчтөнүүдээс асуумжаар дата мэдээлэл цуглуулан статистик дүн шинжилгээ хийхэд хавдартай өвчтөнүүдийн нас, хүйс, боловсролын түвшин зэрэг нь тусламж үйлчилгээний чанарын үнэлгээтэй хамааралгүй буюу бидний судалгааны үр дүнгээс ялгаатай байв. сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлж байна.

Дүгнэлт:

1. Хорт хавдартай үйлчлүүлэгчид нийт сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг хангалттай буюу сайн гэж үнэлсэн байв. Дэд бүлгээр нь авч үзвэл дэмжсэн байдал, холбоо хамааралтай байдал, үнэ цэнэтэй байдал, хүндлэгдсэн байдлын тусламж үйлчилгээ сайн, харин итгэл үнэмшлийн дэд бүлэг дунд түвшинд үнэлэгдсэн байна.
2. Хорт хавдартай өвчтөний сувилахуйн тусламжийн чанарын үнэлгээнд хүйс болон боловсрол нь ач холбогдол бүхий хүн ам зүйн чухал нөлөөлөгч хүчин зүйл байв.

Ном зүй:

1. *Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв (2021). Эрүүл мэндийн статистикийн тоон үзүүлэлт, 2021 ЭМХТөв, Улаанбаатар хот. http://hdc.gov.mn/*
2. *Хавдар Судлалын Үндэсний Төвийн вэб сайт 2023 http://www.cancer-center.gov.mn/home/*
3. *Gaalan K, Kunaviktikul W, Akkadechanunt T, Wichaikhum OA, Turale S. Factors predicting quality of nursing care among nurses in tertiary care hospitals in Mongolia. Int Nurs Rev. 2019;66(2):176-182. doi:10.1111/inr.12502*
4. *Tsogbadrakh B, Kunaviktikul W, Akkadechanunt T, et al. Development and psychometric testing of quality nursing care scale in Mongolia. BMC Nurs. 2021;20(1):68. Published 2021 Apr 28. doi:10.1186/s12912-021-00586-3*
5. *Lucero RJ, Lake ET, Aiken LH. Variations in nursing care quality across hospitals. J Adv Nurs. 2009;65(11):2299-2310. doi:10.1111/j.1365-2648.2009.05090.x*
6. *Kunaviktikul W, Anders RL, Chontawan R, et al. Development of indicators to assess the quality of nursing care in Thailand. Nurs Health Sci. 2005;7(4):273-280. doi:10.1111/j.1442-2018.2005.00247.x*
7. *Burhans LM, Alligood MR. Quality nursing care in the words of nurses. J Adv Nurs. 2010;66(8):1689-1697. doi:10.1111/j.1365-2648.2010.05344.x*
8. *Charalambous A, Adamakidou T. Construction and validation of the quality of oncology nursing care scale (QONCS). BMC Nurs. 2014;13(1):48. Published 2014 Dec 19. doi:10.1186/s12912-014-0048-4*
9. *Charalambous A, Papadopoulos IR, Beadsmoore A. Towards a theory of quality nursing care for patients with cancer through hermeneutic phenomenology. Eur J Oncol Nurs. 2009;13(5):350-360. doi:10.1016/j.ejon.2009.04.011*
10. *Institute of Medicine, 2004*
11. *Zarzycka D, Bartoń E, Mazur A, Turowski K. Socio-demographic and medical factors associated with patients' satisfaction with nursing care and their perception of pain. Ann Agric Environ Med. 2019;26(2):298-303. doi:10.26444/aaem/90385*
12. *Gishu T, Weldetsadik AY, Tekleab AM. Patients' perception of quality of nursing care; a tertiary center experience from Ethiopia. BMC Nurs. 2019;18:37. Published 2019 Aug 14. doi:10.1186/s12912-019-0361-z*
13. *Redman RW, Lynn MR. Assessment of patient expectations for care. Res Theory Nurs Pract. 2005;19(3):275-285. doi:10.1891/rtnp.2005.19.3.275*
14. *White N, La Salle T, Ashby JS, Meyers J. A brief measure of adolescent perceptions of school climate. Sch Psychol Q. 2014;29(3):349-359. doi:10.1037/spq0000075*

Quality of nursing care among patient with cancer in Mongolia

Shinejargal G[1,2], Basbish Ts[1], Lee Won hee[3]

[1]School of Nursing, MNUMS
[2]Intensive care unit-National Cancer Center of Mongolia
[3]School of Nursing, IUU
E-mail: newjargal0101@gmail.com, Tel: +976-88006632

Background: According to the World Health Organization, worldwide there were 19 million people diagnosed with cancer in 2022 and in that same year, 9.9 million people died from cancer. In Mongolia, 5,981 people were diagnosed with cancer in 2021, and 4,559 people died of cancer. Among them 72.5% of cancer patients are diagnosed at a late stage, and 60% of them die less than a year after diagnosis, while 80% of people with the disease are over the age of 45 (Center for Health Development, Mongolia 2021). Within Mongolia, 24,000 people receive treatment and nursing care under the supervision of the National Cancer Center. (National Center for Cancer Research website) In 2013, a consumer satisfaction survey conducted in Mongolian public healthcare hospitals showed that 62.4% of clients were not satisfied with their medical care and services (Gaalan et al., 2018). A comfortable, clean environment, respectfulness and helpfulness of nurses, and explanation of procedures performed by nurses had a significant influence on patient satisfaction in Mongolia. (Tsogbadrakh et al., 2016) This research was conducted because there are currently no studies examining nursing care at the National Cancer Center.

Aim: To investigate the factors related to level of quality nursing care among cancer patients at the National Cancer Center Hospital in Mongolia.

Materials of Methods: A convenience sampling method was used to select 265 inpatients at the National Cancer Center. The socio-demographic questionnaire had 8 items. The Quality Oncology Nursing Care Scale-QONCS questionnaire was used. This questionnaire consists of 34 items and 5 sub-dimensions to assess the quality of nursing care based on patients' perceptions and expectations of nursing care during hospitalization.

The study data were analyzed by using SPSS 21.0 software. Demographic data was assessed using descriptive statistics and correlation of the results were determined by Pearson's correlation analysis. The relationship between the client's gender, education, income, and quality of care was determined by multiple regressions. A value of $p \geq 0.05$ was considered as statistically significant.

Results: The mean score of the quality of nursing care assessment was 136.96±19.54, which means that the cancer patients rated the overall quality of nursing care as satisfactory or good. Considering the subgroups, the average score of the client support subgroup is 70.86±9.20; the average score of connectedness is 18.44±5.15; the average subgroup score for value is 17.93±2.45; and the average score of respectability is 13.23±2.00, which means that these care services are rated at a good level by the evaluation of cancer patients. However, the average score of beliefs was 16.49±7.65, which was rated at a medium level by the evaluation of cancer patients. Therefore, it suggests that nurses should consider patient belief and spirituality in care when providing nursing care to cancer patients. Correlation of the evaluation of the quality nursing of care and gender was negative and weak ($r=-0.152$, $p=0.013$) and the relationship between the assessment of the quality of nursing care and the educational level of the study participants was also negative and weak ($r=-0.25$, $p=0.0001$). According to multiple regression analysis results, gender ($R2=.02$) and education ($R2=.06$) are predictor variables of patients' evaluation of nursing care quality.

Conclusions:

1. Clients with cancer rated the overall quality of nursing care as satisfactory. The subdimensions of being supported and confirmed, sense of belonging, being valued, and being respected are assessed as satisfactory; while the spiritual care sub-dimension was rated at a moderate level.
2. Gender and education were significant related to the factors in the evaluation of the quality of nursing care among patients.

Keywords: Quality nursing care, Patient perception, Patient with cancer, Nurse, Tertiary care hospital